



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/534

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.7.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн бус байгууллага, нөхөрлөлүүдийн санаачилгаар Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, иргэдэд экологийн боловсрол олгох “Экологийн боловсрол 2020” бүсчилсэн сургалт зохион байгуулах арга хэмжээнд зориулан 30000000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дөрвөн бүсэд болох арга хэмжээнд зарцуулагдах 30000000 төгрөг /гучин сая/-ийг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.6 дахь заалтын “Ногоон хөгжлийн хөтөлбөр”-ийн зардлаас тооцож, олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/534 Ch
02 02350